Хуримтлагдсан элэгдэл	(187,685.6)	(174,074.3)	13,611.3
<b>Нийт хөрөнгө</b>	890,506.4	876,815.9	(13,690.5)
Өр төлбөр	92,964.5	187.8	(92,776.6)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	797,541.9	876,628.0	79,086.1
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	890,506.4	876,815.9	(13,690.5)

Эх сурвалж: 2022 оны санхүүгийн тайлан

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 85,972.7 мянган төгрөгөөр өссөн нь ЭМЯ-ны Санхүү эдийн засгийн газрын санхүү даатгалын хэлтсээс өгсөн чиглэлийн дагуу тайлант хугацааны төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг татан төвлөрүүлээгүй байна.

Авлага дансны өөрчлөлт нь өмнөх оны ЭМД-ын сангаас авах авлагын үлдэгдэл 310,758.8 мянган төгрөгийн авлагыг барагдуулсантай холбоотой байна.

Урьдчилгаа дансны үлдэгдэл 150.0 мянган төгрөг болж 950.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 163,849.9 мянган төгрөг болж 99,468.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд нийт 242,428.1 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, аймгийн ЭМГ болон ЭМГ-аар дамжуулан ЭМЯ бусад байгууллагаас 34,800.9 мянган төгрөгийн бараа, материалыг шилжүүлэн авч, 176,782.9 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, 977.6 мянган төгрөгийн бараа материалыг акталж, данснаас хассан нь нөлөөлсөн байна.

Тайлант оны эцэст 466ш 36533.4 мянган төгрөгийн Ремдесивир тарилгын үлдэгдэлтэй байгаа нь оны эцсийн бараа материалын дансны үлдэгдлийн 22.3%-ийг, үүнээс эмийн үлдэгдлийн 70.5%-ийг тус тус эзэлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 800,917.6 мянган төгрөг болж 98,965.8 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 129,296.3 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, аймгийн ЭМГ-аас 25,435.0 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авч, Аймгийн ИТХ-ын хуралдааны тогтоол 2022.09.16-10/46-тоот тогтоолоор 55,765.5 мянган төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хассан нь нөлөөлжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 876,628.0 мянган төгрөг болж 79,086.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд ЭМД-ийн сангаас санхүүжих нэг иргэнээр тооцсон зардлыг 534,805.5 мянган төгрөгөөр төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 105,645.1 мянган төгрөгөөр бууруулан 429,160.4 мянган төгрөгөөр баталжээ.

Тайлант хугацаанд нэг иргэнээр тооцсон санхүүжилтийг хүн амд үзүүлэх тусламж үйлчилгээний гүйцэтгэлээр санхүүжүүлсэнтэй холбоотой 8 удаа төсөвт өөрчлөлт оруулжээ

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр ЭМД-ийн сангаас 501,982.2 мянган , дээд шатны төсөв захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилан олгох буюу туслах үйл ажиллагааны орлогоос 158,918.4 мянган, орон нутгийн төсвөөс санхүүжих тогтмол зардлын санхүүжилтэд 28,084.0 мянган , нийт зарлага санхүүжилтийг 688,984.6 мянган төгрөгөөр баталжээ.

Гүйцэтгэлээр ЭМД-ийн сангаас 509,031.2 мянган, нэмэлт санхүүжилтийн орлогоор 157,918.5 мянган, туслах үйл ажиллагааны орлогоор 32,144.0 мянган, орон нутгийн төсвөөс 28,084.0 мянга, нийт 727,177.6 мянган төгрөгийн санхүүжилтийг авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 639,988.6 мянган төгрөг буюу 92.9 хувьтай байгаа нь тогтмол зардлын санхүүжилтээс зарцуулаагүй үлдэгдлийн 1,216.4 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн, ЭМД-ийн сангаас авах санхүүжилтийг гүйцэтгэлд суурилан 7,049.0 мянган төгрөгөөр илүү авч, 1,000.0 мянган төгрөгөөр дутуу санхүүжиж, туслах үйл ажиллагааны орлогоор 32,144.0 мянган төгрөгийн санхүүжилт орж, олгосон санхүүжилтээс 85,972.7 мянган төгрөгийг зарцуулаагүй, мөнгөн хөрөнгө дансанд үлдэгдэлтэй байгаатай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
			Зөрүү	Биелэлт
ХӨТӨЛБӨР 71602-Эмнэлгийн тусламж үйлчилгээ	688,984.6	639,988.6	48,996.0	92.9
АРГА ХЭМЖЭЭ 80112 –Нийтлэг үйлчилгээ	28,084.0	26,867.6	1,216.4	96.1
АРГА ХЭМЖЭЭ 80302-Нэг иргэнд ногдох нормативт зардал	286,520.1	258,435.2	28,084.9	90.0
АРГА ХЭМЖЭЭ 81603- Үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ	215,462.1	221,248.1	-5786,0	95.0

АРГА ХЭМЖЭЭ 83603-Дээд шатны төсвөөс хуваарилсан нэмэлт санхүүжилт	158,918.4	133,437.6	25,480.4	81.6
--	-----------	-----------	----------	------

Эх сурвалж: 2022 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд нэмэлт санхүүжилтийн дансаар 310,758.8 мянган төгрөгийн гүйлгээ хийгдсэн нь өмнөх оны ЭМД-гийн сангаас авах авлагын гүйлгээ байна. Нэмэлт санхүүжилтийн дансыг 2022 оны 3-р сарын 31-нээр дуусгавар болгон хаах болсонтой холбоотой зарцуулагдаагүй үлдэгдлийн 55,564.3 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны санхүүжилтийн данс руу хааж, батлагдсан төсвийг нэмэгдүүлж өгсөн байна .

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Гурванбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Глобал капитал аудит” ХХК-нийн аудитор Д.Энхтуяа, Д.Цэцэгмаа нар 2023 оны 1 дүгээр сарын 25-наас эхлэн гүйцэтгэж, чанарын хяналтыг Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар хэрэгжүүлсэн.

Гурванбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 12 дугаар сарын 22-ний өдрийн 67 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны

батлагдсан төсөвт зардлыг сонгож материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тооцож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг завсрын аудит хийх явцад 2022 оны 8-р сарын өөрчлөлтөөр батлагдсан төсөвт зардлын 602,082.6 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 7,326.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75.0%-иар тооцон 5,494.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд 688,984.6 мянган төгрөгийн төсөв батлагдаж, батлагдсан 45,996.0 мянган төгрөгийг хэмнэсэн ба төрийн хэмнэлтийн хуулийн заалтад хамаарах дараах зардлыг хэмнэсэн байна. Үүнээс :

- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 939.8 мянган төгрөг
- Хангамж, бараа материалын зардлаас 17,086.9 мянган төгрөг
- Нормативт зардлаас 9,874.4 мянган төгрөгийг тус тус хэмнэсэн байна

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах явцад тайлант оны эхэнд ковидын эмчилгээний зориулалттай 3397.0 мянган төгрөгийн 47 ш Ремдесивир тарилгын үлдэгдэлтэй байхад 2022.01.26-нд ЭМТ-ийн дарга Г.Сүхбаатар, "Их шүүдэргэнэ Ариунаа" ХХК-ийн захирал Т.Ариунаа нар эм, эмнэлгийн хэрэгсэл худалдах, худалдан авах № 2022/01/26-01 тоот гэрээ байгуулан 40000.0 мянган төгрөгөөр 400 ш-ийг нэг бүрийг нь 100.0 мянган төгрөгөөр худалдан авч, ЭМГ-аас үнэ төлбөргүйгээр 145 ш -ийг 5746.4 мянган төгрөгөөр олгогдсоноос 126 ш 12600.0 мянган төгрөгийн зарцуулалт хийгдэж оны эцэст 466ш 36533.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6.нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх гэснийг зөрчсөн байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тайлант онд тендер зарлаагүй ба дулаанаар хангах, эм, эмнэлгийн хэрэгсэл, шатахуун, хүнсний материал худалдан авах 4 гэрээний 141,901.6 мянган, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн

941,928.2 мянган төгрөгийн 24 гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 283,014.3 мянган төгрөгийн 25 гүйлгээ, өмч хөрөнгөтэй холбоотой 213,584.5 мянган төгрөгийн 9 шийдвэрийн мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд 2022 оны 3 дугаар улирлын байдлаар завсрын аудит хийсэн ба аудитаар зөрчил илрээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар нийт 74,700.9 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд 71,192.9 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж, 3,507.3 мянган төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага өгсний хэрэгжилтийн тайланг 2022.05.19-ний өдрийн 37 дугаар албан бичгээр Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлж, Fas программд хэрэгжилтийг мэдээлж ажилласан байна. Өгсөн албан шаардлагаас 2,511.9 мянган төгрөгийг барагдуулаагүй байгаа ба хуваарийн дагуу 2023 оны 4-р сард багтаан төлж барагдуулахаар тохирсон болно.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	71,192.9	2	71,192.9	100
Албан шаардлага	2	3,507.3	1	995.4	28.4
Нийт дүн	4	74,700.2	3	72,188.3	96.6

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар эмийн үлдэгдэл жил бүр нэмэгдэж байгаа тул төсвийн хөрөнгөөр худалдан авч байгаа болон бусад эх үүсвэрээс үнэ төлбөргүй нийлүүлэгдэж байгаа эмийн хугацаа, ашиглалт дээр анхаарч дүн шинжилгээ хийж төсвийн хөрөнгийн үр нөлөөг сайжруулах, төсвийн хөрөнгөөр авч буй үндсэн хөрөнгийн худалдан авах ажиллагаа хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх, түүний чанар, ашиглалтын байдалд Эрүүл мэндийн салбарын хэмжээгээр давтан аудит хийхэд анхаарлаа хандуулах шаардлагатай байна.

#### 5. Аудитын илрүүлэлт

Аудитаар 36,958.4 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрч, 425.0 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 36,533.4 мянган төгрөгийн зөрчилд аймгийн ЭМГ-т албан шаардлага өгөв.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

### 5.1. Төлбөрийн акт

1. Эрхлэгч эмч Г.Сүхбаатар 2022 оны 8 сард 4 хоног ажилласан байхад ажил хавсарсны нэмэгдлийг бүтэн сараар тооцож 275.0 мянган төгрөгийг илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5. батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах гэснийг зөрчсөн, санхүүгийн тайлагналын “Үнэлгээ ба хуваарилалт”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Илүү олгосон цалин 275.0 мянган төгрөгийг Г.Сүхбаатараар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

2.Өмнөх оны санхүүгийн тайланд тусгагдсан урьдчилгаа цалингийн авлага 150.0 мянган төгрөгийг барагдуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8.төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх гэснийг зөрчсөн .

**Шийдвэрлэсэн нь:** Өмнөх оны урьдчилгаа цалингийн авлага 150.0 мянган төгрөгийг холбогдох ажилтнаар төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

### 5.2 Албан шаардлага

1. Тайлант оны эхэнд ковидын эмчилгээний зориулалттай 3397.0 мянган төгрөгийн 47 ш Ремдесивир тарилгын үлдэгдэлтэй байхад 2022.01.26-нд ЭМТ-ийн дарга Г.Сүхбаатар, "Их шүүдэргэнэ Ариунаа" ХХК-ийн захирал Т.Ариунаа нар эм, эмнэлгийн хэрэгсэл худалдах, худалдан авах № 2022/01/26-01 тоот гэрээ байгуулан 40000.0 мянган төгрөгөөр 400 ш-ийг нэг бүрийг нь 100.0 мянган төгрөгөөр худалдан авч, ЭМГ-аас үнэ төлбөргүйгээр 145 ш -ийг 5746.4 мянган төгрөгөөр олгогдсоноос 126 ш 12600.0 мянган төгрөгийн зарцуулалт хийгдэж оны эцэст 466ш 36533.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6.нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх гэсэнтэй нийцэхгүй байгаа ба тус тарилгын ашиглалтын хугацаа 2023 оны 8-р сард дуусахаар байгаа нь төсвийн хөрөнгийн үр ашиггүй зарцуулалт гарахаар байна.

**Шийдвэрлэсэн нь:** Аймгийн ЭМГ-т тус эмийн үлдэгдлийн ашиглалтын хугацаанд хяналт хийж , буруутай албан тушаалтанд хариуцлага тооцох, төсөвт учирч болзошгүй хохирлыг шийдвэрлэх албан шаардлага хүргүүлэх

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал (мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой</b>								
Тайлант оны эхэнд ковидын эмчилгээний зориулалттай 3397.0 мянган төгрөгийн 47 ш Ремдесивир тарилгын үлдэгдэлтэй байхад 2022.01.26-нд ЭМТ-ийн дарга Г.Сүхбаатар, "Их шүүдэргэнэ Ариунаа" ХХК-ийн захирал Т.Ариунаа нар эм, эмнэлгийн хэрэгсэл худалдах, худалдан авах № 2022/01/26-01 тоот гэрээ байгуулан 40000.0 мянган төгрөгөөр 400 ш-ийг нэг бүрийг нь 100.0 мянган төгрөгөөр худалдан авч, ЭМГ-аас үнэ төлбөргүйгээр	1	36,533.4			1	36533.4		

**Гурванбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

145 ш -ийг 5746.4 мянган төгрөгөөр олгогдсоноос 126 ш 12600.0 мянган төгрөгийн зарцуулалт хийгдэж оны эцэст 466ш 36533.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6.нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх гэсэнтэй нийцэхгүй байгаа ба тус тарилгын ашиглалтын хугацаа 2023 оны 8-р сард дуусахаар байгаа нь төсвийн хөрөнгийн үр ашиггүй зарцуулалт гарахаар байна.												
Дүн	1	36.533.4	0	0	1	36,533.4						

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл (мянган төгрөгөөр)**

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Эрхлэгч эмч Г.Сүхбаатар 2022 оны 8 сард 4 хоног ажилласан байхад ажил хавсарсны нэмэгдлийг бүтэн сараар тооцож 275.0 мянган төгрөгийг илүү олгосон байна.	1	275.0	1	275.0								
Өмнө оны санхүүгийн тайланд тусгагдсан урьдчилгаа цалингийн авлага 150.0 мянган төгрөгийг барагдуулаагүй байна.	1	150.0	1	150.0								
<b>ДҮН</b>	<b>2</b>	<b>425.0</b>	<b>2</b>	<b>425.0</b>								

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---oOo---



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ГУРВАНБУЛАГ СУМЫН ЭРҮҮЛ  
МЭНДИЙН ТӨВ**

123 дугаар байр, Төвийн 1 дүгээр гудамж,  
Пионертолгой 5 дугаар баг,  
Гурванбулаг сум, Баянхонгор аймаг, 64239  
Цахим шуудан: gurwanbulag@moh.bkh.gov.mn

2023.02.27 № 27

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г


Г

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудлын  
бүртгэлд санал, тайлбар хүргүүлэв.

Хавсралт 1 хуудастай

ДАРГА *Г. Сүхбаатар* Г. СУХБААТАР



642204212

ТАЙЛБАР


Хавсралт-1

№	Ажил гүйлгээний анги, дансны үлдэгдэл, тодруулга	Алдаа, зөрчлийн товч утга	Шалгагдагч байгууллагын санал, тайлбар
А	1	2	3
1	Ажил гүйлгээний анги-Батлагдсан төсөв, гүйцэтгэл, төсөвт зардлыг эдийн засгийн ангилалын дагуу зарцуулаагүй байх	Тайлант оны эхэнд ковидын эмчилгээний зориулалттай 3397.0 мянган төгрөгийн 47 ш Ремдесивир тарилгын үлдэгдэлтэй байхад 40000.0 мянган төгрөгөөр 400 ш-ийг нэг бүрийг нь 100.0 мянган төгрөгөөр 2022.01.26-нд ЭМТ-ийн дарга Г.Сүхбаатар, "Их шүүдэргэнэ Ариунаа" ХХК-ийн захирал Т.Ариунаа нар эм, эмнэлгийн хэрэгсэл худалдах, худалдан авах № 2022/01/26-01 тоот гэрээ байгуулан 40000.0 мянган төгрөгөөр 400 ш-ийг нэг бүрийг нь 100.0 мянган төгрөгөөр худалдан авч, ЭМГ-аас үнэ төлбөргүйгээр 145 ш-ийг 5746.4 мянган төгрөгөөр олгогдсоноос 126 ш 12600.0 мянган төгрөгийн зарцуулалт хийгдэж оны эцэст 466ш 36533.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6.нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх гэсэнтэй нийцэхгүй байгаа ба тус тарилгын ашиглалтын хугацаа 2023 оны 8-р сард дуусахаар байгаа нь төсвийн хөрөнгийн үр ашиггүй зарцуулалт гарахаар байна.	466ш 36533.4 мянган төгрөгийн Ремдесивир тарилгын үлдэгдэлийн: 3397.0 мянган төгрөгийн үнэ бүхий 47ш нь оны эхний үлдэгдэл, 27400.0 мянган төгрөгийн үнэ бүхий 274ш нь "Их шүүдэргэнэ Ариунаа" ХХК-аас худалдан авсан, 5736.4мянган төгрөгийн үнэ бүхий 145ш нь ЭМГ-с /2022 оны 10-р сард 20ш, 12-р сард 125ш/ олгосон. 2022 оны 07-р сарын 24-с 08-р сарын 06-ны хооронд нэг бүр нь 100.0 мянган төгрөгийн үнэ бүхий 42ш Ремдесивир Ковидын эмчилгээнд хэрэглэснийг Ахлах сувилагч зарцуулалтыг нь гаргаагүй орхигдуулсан байсныг илрүүлсэн. Тухайн 42ш эмийн зарцуулалтыг хэрхэн шийдвэрлэх талаар зөвлөгөө өгөхийг хүсч байна. Нийт Ремдесивир тарилгын үлдэгдэл 32333.4мянган төгрөгийн үнэ бүхий 424ш байна.
2	Ажил гүйлгээний анги-Цалин, НДШ, ХХОАТ-ын зардлыг илүү дутуу тооцох,	Өмнөх оны урьдчилгаа авлага 150.0 мянган төгрөгийг баргадуулаагүй байна.	2015 онд үүссэн цалингийн урьдчилгаа бөгөөд, тухайн албан хаагч нь ажлаас гарсан. Иймд тухайн хүнтэй холбогдож энэ онд авлагыг бүрэн барагдуулах болно.

ТАЙЛБАР БИЧСЭН:

ДАРГА

НЯГТЛАН БОДОНЧ



/Г.СҮХБААТАР/

/Б.ӨЛЗИЙМАА/



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2023 оны 02 сарын 17 өдөр

Дугаар 21/14425182

Номгон

БНА-2023/56/НА-ТА-ТУЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрхлэгч эмч Г.Сүхбаатар 2022 оны 8 сард 4 хоног ажилласан байхад ажил хавсарсны нэмэгдлийг бүтэн ажилласнаар тооцож 275,040 төгрөгийг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5. батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах гэснийг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.5.бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн, 4.2.3.8 дахь "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Илүү олгосон цалин 275,040 /Хоёр зуун далан таван мянга дөчин/ төгрөгийг ажилтан Г.Сүхбаатараар төлүүлж, Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад, татвар хураамжийн орлогын 100030000947 тоот дансанд төвлөрүүлэх<sup>1</sup>

2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2023 оны 04 дүгээр сарын 15-ний дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын Эрүүл мэндийн төвийн дарга Г.Сүхбаатар, нягтлан бодогч Б.Өлзиймаа нарт хариуцуулав<sup>2</sup>.

**ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН<sup>3</sup>:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ

"ГЛОБАЛ КАПИТАЛ АУДИТ" ХХК-ИЙН АУДИТОР Д.ЦЭЦЭГМАА



<sup>1</sup> Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

<sup>2</sup> Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

<sup>3</sup> Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно

• 005050063



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2023 оны 02 сарын 17 өдөр

Дугаар

22/24425182

БНА-2023/56/НА-СТА-743

Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны санхүүгийн тайланд тусгагдсан урьдчилгаа цалингийн авлага 150,000 төгрөгийг барагдуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8.төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх гэснийг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.5.бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн, 4.2.3.8 дахь "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Өмнөх оны авлага 150,000 /Нэг зуун тавин мянган/ төгрөгийг холбогдох ажилтнаар төлүүлж, Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад, татвар хураамжийн орлогын 100030000947 тоот дансанд төвлөрүүлэх<sup>1</sup>

2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2023 оны 04 дүгээр сарын 15-ний дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын Эрүүл мэндийн төвийн дарга Г.Сүхбаатар, нягтлан бодогч Б.Өлзиймаа нарт хариуцуулав<sup>2</sup>.

**ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН<sup>3</sup>:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ

"ГЛОБАЛ КАПИТАЛ АУДИТ" ХХК-ИЙН АУДИТОР

Д.ЦЭЦЭГМАА

<sup>1</sup> Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

<sup>2</sup> Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

<sup>3</sup> Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно

005050066



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 02 сарын 17 өдөр

Дугаар 20/14925182  
БНА-2023/124/НА-СТА-7412

Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны эхэнд ковидын эмчилгээний зориулалттай 3397.0 мянган төгрөгийн 47 ш Ремдесивир тарилгын үлдэгдэлтэй байхад 2022.01.26-нд ЭМТ-ийн дарга Г.Сүхбаатар, "Их шүүдэргэнэ Ариунаа" ХХК-ийн захирал Т.Ариунаа нар эм, эмнэлгийн хэрэгсэл худалдах, худалдан авах № 2022/01/26-01 тоот гэрээ байгуулан 40000.0 мянган төгрөгөөр 400 ширхгийг нэг бүрийг нь 100.0 мянган төгрөгөөр худалдан авч, ЭМГ-аас үнэ төлбөргүйгээр 145 ширхгийг 5746.4 мянган төгрөгөөр олгогдсоноос 126 ш 12600.0 мянган төгрөгийн зарцуулалт хийгдэж оны эцэст 466 ширхэг 36533.4 мянган төгрөгийн эмийг нөөцөлсөн байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6.нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх гэсэнтэй нийцэхгүй байгаа ба тус тарилгын ашиглалтын хугацаа 2023 оны 8-р сард дуусахаар байгаа нь төсвийн хөрөнгийн үр ашиггүй зарцуулалт гарахаар байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх "хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Тус эмийн татан авалт, үлдэгдэл, ашиглалтын байдалд хяналт хийж, буруутай албан тушаалтанд хариуцлага тооцох, төсөвт учирч болзошгүй хохирлоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, шийдвэрлэн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2023 оны 04 дүгээр сарын 25-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн

005040635

аудитын газарт ирүүлэхийг Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын дарга Н.Энхжаргалд даалгав<sup>1</sup>.

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Гурванбулаг сумын Эрүүл мэндийн газрын дарга Г.Сүхбаатар-д хариуцуулав.<sup>2</sup>

**АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН<sup>3</sup>:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ

“ГЛОБАЛ КАПИТАЛ АУДИТ” ХХК-ИЙН АУДИТОР

Д.ЦЭЦЭГМАА



<sup>1</sup> Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

<sup>2</sup> Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

<sup>3</sup> Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно